



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/165

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн а/361 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.4.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, ажлын байрыг нэмэгдүүлэн үр өгөөжтэй ажиллан, зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлсөн эсэхэд хяналт тавьж хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийг төлүүлэх, сангийн үйл ажиллагааг тогтворжуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Боргил - Засаг даргын орлогч
Нарийн бичиг: Г.Минжинсор- Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: Г.Лхагвабаатар- Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Г.Цэрэнтогтох – Төрийн сангийн мэргэжилтэн
П.Дархисүрэн- Сангууд хариуцсан нягтлан бодогч
Х.Одонтуяа- Баянмөнх 3-р багийн Зохион байгуулагч
Л.Эрдэнэчимэг- Сариг 4-р багийн Зохион байгуулагч

2.Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж үр дүнг тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч (А.Боргил)-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР